



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 111/2019

101-1231

Арсалт

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.Б.БЯЯРМӨНХ-д
ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Өвөрхангай аймгийн Бүрд сумын 2018 оны ОНХС-ийн Ерөнхийн зарцуулалт, үр дүнд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Бүрд сумын төв талбайг тохижуулах ажлын гүйцэтгэгчээр "Сант хүрэн овоо" ХХК-тай 19.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан ч ТЭЗҮ-гуй ажил төлөвлөсөн, төсөв хүрэлцэхгүйгээс "Сант хүрэн овоо" ХХК нэмэлт санхүүжилт хүссэн байна. Сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 06 ны өдрийн а/109 захирамжаар 10.0 сая төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн боловч гэрээ байгуулаагүй. 2.8 сая төгрөгийн санхүүжилт нэмж олгосон байна. Аудитаар газар дээр нь очиж ажиллагаа гэрээнд заасан ажлыг дуусгаагүй байлаа.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сарын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Эрэн нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалт Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 195 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлаг журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь.

Тус ажилд нэмж санхүүжилтийг олгохгүйгээр гэрээнд заасан хугацаанд ажлыг чанартай гүйцэтгүүлэн, ажлыг хүлээн авч, биелэлтийг 2019 оны 08 дугаар сарын 10-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар албан ёсоор ирүүлэхийг Засаг дарга А.Баярмөнх Санхүүгийн албаны дарга Ц.Март нарт заалгав.

ӨГСӨН:

АЛБАН ШААРДЛАГА

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БЯЯРМӨНХ

АУДИТОР

Ц.ОТГОННЯМ

САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА
Ц.МАРТ

П.ХОРЛООСҮРЭН
Ө.РИНЧИНМЯДАГ

"Албан шаардлага" хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага төлбөрийн акт, гэрээсн албан шаардлага үүрэгт ажлаас нь халах тухай санаа зориулж бусад зөвшөөрөлтэй байх" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь.